



**“ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

“Евразия капитал холдинг ҮЦК” ХК – ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2022 оны 1-р сарын 04-ний өдөр 10 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 3-р хороо, Pearl Tower 11 давхарт 1101 тоот өрөөнд эхлэв.

Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийг холбогдох журмын дагуу бүртгэн авч нийт ирцийг тооллогын комисст хүлээлгэн өгөв.

Энэхүү хуралд компанийн хувьцаа эзэмшигчид болох иргэн Ж.Энхтунгалаг, Г.Оюунболд, “Мезза Файнэншл Групп” ХХК, “Омега Инвест” ХХК, “Вистекс Глобал Инвест” ХХК нар оролцсон бөгөөд нийт 2 224 796 ширхэг хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигчид оролцож байгаа нь нийт саналын эрх бүхий 2 270 892 ширхэг энгийн хувьцааны 98% болж хурал хүчин төгөлдөр эхлэв.

Хурлын дарга Г.Халиунаа:

- Хурлыг нээж, хурлын дэг болон хэлэлцэх асуудлыг танилцуулав. Үүнд:
 1. Компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчилсэн найруулгыг батлах
 2. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, нэмэлт хувьцаа гаргах
 3. Шаардах эрх хэрэгжүүлэх тухай
 4. Бусад.

Хурлаар хэлэлцэх асуудлаа нэг бүрчлэн авч хэлэлцээд тухай бүрд нь асууж тодруулах зүйлээ асууя гэсэн саналтай байна. Та бүхэн юу гэж бодож байна?

Хуралд оролцогчид:

- Зөвшөөрч байна.

Гүйцэтгэх захирал У.Анар:

Компани нь үнэт цаасны зах зээлд брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа явуулдаг. Цаашид гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа явуулах мөн Санхүүгийн Зохицуулах Хорооны холбогдох журамд заасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах шаардлагатай байгаа тул хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай болж байгаа юм. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхдээ олон нийтэд, хаалттай хүрээнд болон стратегийн хөрөнгө оруулагчдад нэр заан эзэмшүүлэх саналтай байна. Хувьцаа нэмж гаргахтай холбоотой үнэ тогтоох, холбогдох төлөвлөгөө, дүгнэлтүүдийг батлах, шаардах эрх хэрэгжүүлэх эрхийг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгох нь цаг хугацаа хэмнээд хурдан шийдвэр гаргах боломжтой гэж үзэж байна.

- Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг та бүхэнд хүргүүлсэн байгаа. Асуух зүйл байвал асуугаарай.

Хувьцаа эзэмшигч “Мезза Файнэншл Групп” ХХК түүнийг төлөөлж Камоллиддин Талипов:

Урьд нь таван тэрбум төгрөгийн хувьцаа нэмж гаргахаар 2 удаа хөндлөнгийн байгууллагуудын дүгнэлт гаргуулж байсан. Одоо болтол шийдэгдэхгүй байгаад

харамсаж байна. Хэрвээ энэ асуудал тухайн үед шийдэгдсэн байсан бол одооны энэ байдалд хүрэхгүй байсан. Таван тэрбум хүртлэх төгрөгийн энгийн хувьцаа нэмж гаргах саналтай байна. Үнэ тогтоох, дүгнэлт батлах эрхийг ТУЗ-д олгох саналтай байна.

Хувьцаа эзэмшигчид:

- Асуух зүйл байхгүй. Дэмжиж байна. Үйл ажиллагааны чиглэлд гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагааг нэмэх нь зөв.

Гүйцэтгэх захирал У.Анар:

Компанийн дүрэмд өөрчлөлт орж байгаатай холбогдуулан 2022 оны 01-р сарын 04 өдөр хуралдсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцоогүй, оролцсон ч эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигчид нь компанид хувьцаагаа эргүүлэн худалдах шаардах эрхийг хэрэгжүүлэх саналтай байна. Нэмж хувьцаа гаргах зөвшөөрлийг төрийн эрх бүхий байгууллага зөвшөөрсний дараа шаардах эрхийн хүрээнд нэгж хувьцааг худалдаж авах үнийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоох, Компанид хувьцаагаа эргүүлэн худалдахаар хүсэлт захиалгаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах үүргийг Компанийн тухай хуулийн 53-р зүйлийн 53.3-т заасны дагуу хяналтын багцын хувьцаа эзэмшигчдэд олгох саналтай байна.

Хувьцаа эзэмшигчид:

- Асуух зүйл байхгүй. Дэмжиж байна.

Хувьцаа эзэмшигч "Мезза Файнэншл Групп" ХХК түүнийг төлөөлж Камоллиддин Талипов:

Хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор таван тэрбум хүртлэх төгрөгийн үнийн дүн бүхий энгийн хувьцааг хаалттай хүрээнд нэмж гаргахтай холбоотойгоор одоогийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх нь зөв байх. Бусад гэх асуудлын хүрээнд Алдагдалтай байхад жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах хэрэгтэй байх.

Хувьцаа эзэмшигчдийн санал хүсэлтийн дараа саналын хуудсыг тооллогын комисст хүлээлгэн өгсний дараа хурлын дарга хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг танилцуулав.

"Санал хураалтанд хуралд оролцогчид 100% оролцож нийт саналын хуудас дахь асуулгыг 100% дэмжсэн байна" хэмээн Тооллогын комиссын дүнг тооллогын комиссын дарга Х.Мөнгөнцэцэг танилцууллаа.

Хурал: 12 цаг 20 минутад өндөрлөв.

Тэмдэглэл хөтөлсөн:

Г.Санжаасүрэн

Хянасан:

Хурлын дарга:

Г.Халиунаа

